

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

MAKING JUVENILE CASE MANAGEMENT ESSENTIAL

Б.Одонгэрэл

*СИТИ Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал,
доктор (Ph.D), дэд профессор*

Товч агуулга: Энэхүү өгүүллээр Монгол Улсад насанд хүрээгүй хүний эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах арга замын талаар хөндөхийг зорилоо. Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг тусгайлан зохицуулсан ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүүхдийн эрхийг бүрэн хангаж чадахгүй байна. Монгол Улсын хэмжээнд хүүхдийн гэмт хэрэгт холбогдсон байдлыг авч үзвэл, 2018 онд 956, 2019 онд 1356, 2020 онд 990, 2021 онд 921, 2022 онд 1540 хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь хүн амтай харьцуулахад бага тоо биш юм.

Японд насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас гадна Хүүхдийн тухай хууль гэж нэрлэгддэг тусдаа хуулиар зохицуулагддаг бөгөөд хэргийг гэр бүлийн шүүх гэж нэрлэгддэг тусдаа шүүх шийдвэрлэдэг. Сүүлийн жилүүдэд зөвхөн Япон гэлтгүй Солонгос, Сингапур зэрэг Азийн орнуудад насанд хүрээгүйчүүдийн тусгай шүүх байгуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нийгэмшүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа сайн туршлага сүүлийн үед бий.

Тиймээс Монгол Улсад Азийн бусад орны жишгээр насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийн шүүхийг тусад нь байгуулах шаардлагатайг илтгэлээр хэлэлцэх юм. Ингэхдээ Япон, Солонгос, АНУ-ын жишиг туршлагыг судалж, өөрийн орны нөхцөл байдалтай харьцуулан тодорхой арга замыг эрэлхийлсэн.

Abstract: In this report, we will discuss the analysis of the current situation in which the Juvenile criminal procedure in Mongolia and ways to improve the handling of cases in the future. Although the 2015 updated Criminal Code of Mongolia specifically regulates the imposition of criminal responsibility on juveniles (14-18 age) and the criminal proceedings under the Criminal Procedure Code, the proceedings cannot fully satisfy children's rights. Considering the involvement of children in crime in Mongolia, 956 children were investigated for crime in 2018, 1356 in 2019, 990 in 2020, 921 in 2021, and 1540 in 2022, which is not a small statistic compared to the population.

Juvenile proceedings in Japan are governed by a separate law called the Juvenile Law in addition to the Criminal Procedure Law, and cases are resolved by a separate court called the Family Court. In recent years, not only in Japan, but also in other Asian countries such as Korea and Singapore, there are good experiences of establishing especial courts for juveniles and effectively implementing case proceedings and socialization recently.

Therefore, the report will discuss the need to establish a separate court for juvenile offenders in Mongolia, following the standards of other Asian countries. In doing so, we studied the standard experience of Japan, Korea, and the United States, and compared it with the situation in our own country, looking for a specific way.

Түлхүүр үгс: Насанд хүрээгүй хүн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, реабилитацийн систем

Keywords: Juvenile, judicial proceedings, legal regulation, rehabilitation system

Үндсэн хэсэг

Монгол Улс хүүхдийн эрхийг ханган хамгаалах талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулах чиглэлд чамлахааргүй хүчин чармайлт гаргаж байна гэж Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлд дурджээ.¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан. Үүний дагуу хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангаж хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлж, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Эрүүгийн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулиуд шинэчлэн батлагдаж, хүүхэд хамгааллын хамтарсан баг, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо зэрэг хүүхэд хамгааллын шинэ механизмууд ажиллаж байна. Эдгээр нь хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах боломж, нөхцөл өргөн хүрээнд бүрдсэн гэж комисс мөн дүгнэжээ.²

Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлд өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг заахдаа “Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэжээ. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна³ гэж Эрүүгийн хуульд тусгайлан бүлэглэж хуульчилсан нь гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн эрхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хангахад чиглэсэн томоохон алхам болжээ. Түүнчлэн шүүхээс арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно гэж заасан нь 14-21 насны хүнд энэхүү бүлэгт заасан журам үйлчлэхийг тодотгожээ.

Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалт: Олон улсын ба гадаадын улсын харьцуулсан судалгаа

Насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах, ялангуяа хэрэг хянан шийдвэрлэх асуудлыг тусгайлан авч үзэхэд чиглэсэн олон улсын баримт бичгүүдийн хамгаалалтын тогтолцоонд Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц⁴, Хүүхдийн эрх, сайн сайхны тухай НҮБ-ын Африкийн дүрэм⁵, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Шүүхийн Хэрэг эрхлэх доод жишиг дүрэм (Бээжингийн дүрэм), Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүнийг хамгаалах НҮБ-ын Удирдамж, Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын Удирдамж (Эр-

¹ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023 он, 327 дахь тал. <https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf>

² Мөн тэнд.

³ Эрүүгийн хууль, 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/1276>

⁵ https://au.int/sites/default/files/treaties/36804-treaty-african_charter_on_rights_welfare_of_the_child.pdf

Риядын удирдамж), Дэлхийн Эрүүгийн процессын загвар хууль (Model Code of Criminal Procedure) зэргийг хамааруулж болох юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг ханган хамгаалах талаар олон улсад онцгойлон авч үзэх талаар Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлд “нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна” гэж, НҮБ-ын 1985 онд баталсан Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмийн 17.1 дүгээр зүйлийн б-д “Насанд хүрээгүй хүний эрх чөлөөг хязгаарлах шийдвэрийн асуудлыг нарийвчлан, хянан хэлэлцсэний дараа энэ хязгаарлалтыг бололцооны хирээр хамгийн багаар тогтооно... 17.1-ийн тайлбарын 4 дэх хэсэгт “Хорихоос өөр төрлийн ял хэрэглэх боломжийг ямагт харгалзах... Насанд хүрээгүй хүний сайн сайхан байдал, ирээдүйг хангах сонирхол ямагт тодорхойлогч хүчин зүйл, харгалзах баримт болно...” гэж тус тус заасан.

Дэлхийн Эрүүгийн процессын загвар хууль (цаашид Процессын загвар хууль гэх) нь эрүүгийн эрх зүйн үйл ажиллагаа, процессын тухай нийтлэг стандартуудыг (үүнд: гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа багтана) тогтоож, улс орнуудад тэрхүү наад захын стандартыг бий болгох үүднээс үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэн хөгжүүлэх шаардлагыг дэвшүүлдэг. Тус Загвар хуулийн зорилго нь шударга байдал, тэгш байдлыг хангах, тамлан зовоох, эрүүдэн шүүхтэй тэмцэх, хуулийн тогтворжилт, нэгдмэл байдлыг хангах, Эрүүгийн шүүхийн үйл ажиллагааг хялбаршуулах: Процессын бүх шатанд үйл ажиллагааг тодорхой, хялбар болгох юм. Иймд насанд хүрээгүй хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах наад захын стандартуудыг тоймлон ЭХХШТХ-ийн 18 дугаар бүлэг болон холбогдох бусад эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзье.

1. Дэлхийн Эрүүгийн Процессын загвар хуульд нэн тэргүүнд энэхүү juvenile буюу гэмт хэрэг үйлдсэн хүүхэд гэдэгт ямар насны хүнийг хамруулах тухай заасан.⁶

Монгол Улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өсвөр насны хүн, насанд хүрээгүй хүн, хүүхэд гэсэн нэр томъёог янз бүрээр хэрэглэж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэрэг хуулиудад “хүүхэд” гэж, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “өсвөр насны хүн”, “насанд хүрээгүй хүн”⁷ гэж хэрэглэж байгаа бол, 2002 оны Эрүүгийн хууль,⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “насанд хүрээгүй этгээд” гэх нэр томъёог хэрэглэж байсан⁹ бөгөөд насны хувьд тодорхойлохдоо “арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүн”¹⁰ гэж, харин 14 насанд хүрээгүй бол “бага насны хүүхэд” гэсэн нэр томъёог¹¹ хэрэглэж байна.

Тэгвэл олон улсад хүүхэд гэсэн нэр томъёо, түүний насны хязгаарыг тодорхойлохдоо Хүүхдийн эрхийн конвенцод “энэхүү Конвенцын зорилгод тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу тэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг

⁶ Дэлхийн Эрүүгийн процессын загвар хууль, 1 дүгээр зүйл (26)

⁷ Эрүүгийн хууль, 3.2 дугаар зүйл. ЭХХШТХ-ийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.

⁸ Эрүүгийн хуулийн 55,56,62,69 зэрэг 12 зүйлд энэ нэр томъёог хэрэглэжээ. 2002 он, <https://legalinfo.mn/mn/detail/12172>

⁹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 37 дугаар зүйл зэрэг 35 зүйлд насанд хүрээгүй этгээд гэсэн нэр томъёогоор хүүхдийг тодорхойлсон, 2002 он, <https://legalinfo.mn/mn/detail/59>

¹⁰ Эрүүгийн хууль, 8.1 дүгээр зүйл.

¹¹ Эрүүгийн хууль, 10.1 дүгээр зүйлийн Тайлбар: -Энэ хуульд заасан "бага насны хүүхэд" гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно.

хүүхэд гэнэ.”¹², Дэлхийн Эрүүгийн загвар хуулийн 1 дүгээр зүйлд “хүүхэд гэж 18 наснаас доош насны хүнийг хэлнэ.”¹³ гэжээ. Харин өсвөр насны хүнийг Дэлхийн Эрүүгийн загвар хуульд “өсвөр насны хүн (juvenile) гэж 12-18 насны хүнийг хэлнэ” насанд хүрээгүй хүн гэсэн нэр томъёог Дэлхийн Эрүүгийн Процессын загвар хуулиар тодорхойлохдоо арван хоёроос арван найман насны хүүхэд¹⁴ гэж тус тус тодорхойлсон бол 1985 оны НҮБ-н өсвөр насны хүнд хэрэглэх шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм буюу Бээжингийн дүрмийн 2 дугаар зүйлд өсвөр насны хүн нь тухайн улсын эрх зүйн тогтолцоонд тодорхойлсон бол гэмт хэрэг үйлдсэн хүүхэд болон залуу хүн байж болно гээд тайлбар хэсэгтээ өсвөр насны гэмт хэрэгтнийг 7-18 нас ба түүнээс дээш насны хүрээнд тодорхойлж болох талаар дурджээ.¹⁵

2. Насанд хүрээгүй хүний хэргийг шийдвэрлэхэд оролцох тусгай зөвлөл, хүүхдийн тусгайлсан шүүх байх шаардлагатайг заажээ.

Процессын загвар хуульд анхан болон давж заалдах шатны шүүхэд насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх шүүгчдийн тусгай бүрэлдэхүүн (зөвлөл)-ийг томилох тухай заасан.¹⁶ Сэжигтэн, яллагдагч нь насанд хүрээгүй хүн байх бүхий л тохиолдолд энэхүү тусгай зөвлөлөөр заавал хэлэлцүүлж байхыг улс орнуудад даалгасан юм. Тусгай зөвлөл нь насанд хүрээгүй хүний холбогдох гэмт хэргийн талаар зохих мэдлэг чадвар, туршлагатай, сургалтад хамрагдсан 3 шүүгчийн бүрэлдэхүүнээс бүрдэнэ.¹⁷ Энэхүү тусгай зөвлөл нь Хүүхдийн тусгай шүүхээс ялгаатай. Эрүүгийн эрх зүйн зарим эрдэмтэд улс бүр заавал хүүхдийн эрүүгийн хэргийн шүүхтэй байх ёстой гэж үздэг бол зарим нь пост-социалист болон хүний нөөцийн хомсдолтой улс орнуудад хүүхдийн эрүүгийн тусгай шүүх байгуулах боломжгүй тул дор хаяж энэхүү загвар хуулиар хүүхдийн тусгай зөвлөлийг байгуулах стандартыг хуульчлах шаардлагатай гэж энэхүү шийдлийг оруулжээ. Тусгай зөвлөл нь Процессын загвар хуулийн дагуу дангаар болон бүрэлдэхүүнээр хүүхдийн хэргийг шийднэ. Процессын загвар хуулиар аливаа улс боломжтой тохиолдолд хүүхдийн эрүүгийн шүүхийг тусад нь байгуулахаар эрмэлзэх ёстойг тодотгоод ийм тогтолцоонд шилжих хүртэл анхан болон давж заалдах шүүхүүдэд насанд хүрээгүй хүний хэргийг дагнан шүүх тодорхой тооны шүүгчдийг томилох нь зөв шийдэл юм гэжээ.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүний шүүх (Juvenile court)

Олон улсад хүүхдийн зүгээс үйлдсэн гэмт хэргийг тусгайлан шийдвэрлэх Насанд хүрээгүй хүний шүүх буюу Juvenile court (цаашид Juvenile court гэх) ажилладаг. Энэхүү тусгай шүүх нь хүүхдийн сэтгэл зүйг хамгаалах, тусгай сургалт, нийгэмшүүлэх хөтөлбөрт хамруулах, хүүхдийг илүү эерэг орчинд хүмүүжүүлэх зорилгоор шийдвэр гаргагдаараа онцлогтой юм. Гэмт хэрэгтэн хүүхэд нь насанд хүрсэн гэмт хэрэгтэнтэй харьцуулахад олон талаараа ялгаатай бөгөөд иймд хэрэг хянан шийдвэрлэх процесс төдийгүй оногдуулах ял шийтгэл нь хүүхдийг хүмүүжүүлэх, тэдний ирээдүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэсэн өвөрмөц зорилгыг агуулдаг.

АНУ-д Иллиной муж (Illinois)-ийн Насанд хүрээгүй хүний шүүхийн тухай хууль нь 1899 онд батлагдаж, анх удаа 18 наснаас доош хүүхдэд онцгой дүрэм, процессоор хэрэг хянан

¹² Хүүхдийн эрхийн конвенцийн 1 дүгээр зүйл.

¹³ Model Codes for Post-Conflict Criminal Justice, Article 1, <https://www.usip.org/model-codes-post-conflict-justice-/volume-1>

¹⁴ Дэлхийн Эрүүгийн процессын загвар хууль (Model Code of Criminal Procedure)-ийн 1-р зүйлийн 26 дахь хэсэгт.

¹⁵ United Nations Standard Minimum Rules for the Administration of Juvenile Justice ("The Beijing Rules"), Article 3, <https://www.ohchr.org/sites/default/files/Documents/ProfessionalInterest/beijingrules.pdf>

¹⁶ Процессын загвар хууль, 322 дугаар зүйл.

¹⁷ Процессын загвар хууль, 322 дугаар зүйл, 3 дахь хэсэг

шийдвэрлэх ажиллагаа явуулахыг хуульчилсан юм. Тус хууль нь өсвөр насны хүнд насанд хүрсэн этгээдээс тусдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуультай байх жишгийг АНУ-д төдийгүй дэлхийн бусад улсад ч дэлгэрүүлсэн юм. Өөрөөр хэлбэл, насанд хүрээгүй хүнд явуулах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг насанд хүрсэн хүнээс ялгасан системийг төлөвшүүлэх нь эрүүгийн шүүхийн тогтолцоонд хамгийн зөв дэвшил болсон гэдгийг АНУ-ын дээд шүүхээс тогтоосон байдаг.¹⁸ Энэхүү Иллиной Насанд хүрээгүй хүний шүүхийн тухай хууль нь “*Parens patriae*” онолд үндэслэгдсэн ба “*Parents patriae*” онол нь латинаар “үндэсний эцэг эх” гэсэн утгатай (шинжээр нь “эх орон- эцэг эх нь байх”) үг бөгөөд энэ нь хүчирхийлэл үйлдсэн, хайхрамжгүй хандсан эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн эсрэг төр тэдгээрийг хамгаалах үүргийг гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу төрийн бүрэн эрхт эрх ашигт нийцүүлэн иргэдийнхээ сайн сайхны төлөөх эрх ашгийг хөндсөн тохиолдолд иргэний нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг сургаал¹⁹ юм. Тухайлбал, зарим хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохих анхаарал халамж тавих чадвартай, хүсэл эрмэлзэлтэй эцэг эх байхгүй тул төрийн оролцоо шаардлагатай байдаг.

Насанд хүрээгүй хүнийг тусгайлсан шүүхээр хэргийг шийдвэрлэхэд тухайн этгээдийн холбогдсон гэмт хэргийн хөнгөн хүнд, хохирогчид хүч хэрэглэсэн эсэх, гэмт хэрэг үйлдсэн арга, хувийн байдал, өнгөрсөн амьдралын түүх, засарч хүмүүжих магадлал зэргийг харгалзан үздэг.²⁰ Ийнхүү тусдаа шүүх нь тухайн хэрэгт холбогдсон этгээдийн шүүх хурлыг хаалттайгаар, тэдний хамаарал бүхий хүмүүсийн хамт, харьцангуй сул ёс зүйн дүрэм буюу чөлөөт зарчим дээр үндэслэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг.²¹ Эрүүгийн шүүхийн тогтолцоонд гэм буруутай нь тогтоогдсоны дараа онц хүнд гэмт хэрэгт ял оногдуулах нь ихэвчлэн хорих ялаар шийтгэгддэг бол насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн тогтолцоо нь аль болох хорихоос зайлсхийхийг эрмэлздэг.²² Өөрөөр хэлбэл, насанд хүрээгүй хүний шүүхийн тогтолцооны үндсэн зорилго нь олон нийтийн аюулгүй байдлыг хангахаас гадна өсвөр насны гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэх, нөхөн сэргээх, сэтгэл зүйн болон бусад эмчилгээ, туслалцаа үзүүлэх, ингэснээр тэднийг нийгэмд амжилттай эргүүлэн оруулах явдал юм.

Juvenile Court нь гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг хүмүүжүүлэх, сэтгэл зүйн болон нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор ажилладаг. Тиймээс эдгээр шүүхүүдийн хамгийн сайн ажилладаг орнууд хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс зайлсхийх, сөрөг үр дагаваргүйгээр амьдралд оруулах зорилготой олон төрлийн шийдлүүдийг хэрэгжүүлдэг. Олон улсын хэмжээнд Швед, Норвег, Австрали, Канад, Нидерланд, Швейцар зэрэг улс орнуудын Juvenile court нь тусгайлан боловсруулсан, үр дүнтэй системтэй бөгөөд олон талт хандлагатай ажилладаг. Эдгээр улс орнууд нь гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, сэтгэл зүйн тусламж үзүүлэх үйл явцыг маш сайн боловсруулж, хүүхдийн сэтгэл зүй, хөгжилд эерэг нөлөө үзүүлэх замаар гэмт хэрэгтнүүдийг хариуцлагатай, эрүүл иргэд болгож чадсан амжилттай туршлагыг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Шведийн Juvenile court нь хүүхдийг гэмт хэрэгтэн биш, “хүмүүжүүлэх шаардлагатай этгээд” гэж үзэж, тэдний сэтгэл зүйн байдал, хүмүүжилд анхаардаг. Шведийн систем нь захиргааны шийдвэрээс илүүтэйгээр боловсрол, сэтгэл зүйн тусламжийг санал болгож, залуу гэмт хэрэгтнүүдийн сэтгэл зүйг сэргээж, нийгэмд эрүүл орчинд оруулахад

¹⁸ <https://www.cairn.info/revue-internationale-de-droit-penal-2004-1-page-535.htm>

¹⁹ https://www.law.cornell.edu/wex/parens_patriae#:~:text=The%20doctrine%20of%20parens%20patriae,well%2Dbeing%20of%20its%20citizens

²⁰ <https://www.cairn.info/revue-internationale-de-droit-penal-2004-1-page-535.htm>

²¹ Мөн тэнд.

²² <https://youth.gov/youth-topics/juvenile-justice>

анхаардаг. Өөрөөр хэлбэл, шүүх нь тусгай хүмүүжлийн хөтөлбөрүүд, эмчилгээ, сургалтын хөтөлбөрүүдээр дамжуулан гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг өөрчлөхийг зорьдог.

Канад улсад Juvenile court нь хүүхдийг олон талаас нь дэмжиж, хүмүүжүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг ба Хүүхдийн эрхийн хууль нь хүүхдийг хүмүүжүүлэхэд чиглэж, тэдний ирээдүйн хөгжил, сэтгэл зүйн байдлыг онцгой анхаардаг. Иймд тус улс хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор нийгмийн үйлчилгээ, эмчилгээ, боловсролын хөтөлбөрүүдийг үзүүлдэг.

Финлянд улсад тус шүүх нь сэтгэл зүйн дэмжлэг, сургалт, нийгэмшүүлэх хөтөлбөрүүдийг ашигладаг. Финлянд дахь шүүхүүд нь хүүхдийг хэтэрхий хатуу шийтгэхээс илүүтэйгээр тэдний сэтгэл зүйг ойлгон, зөөлөн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Энэ улс нь реабилитацийн системийг²³ чухалчилж, хүүхдийг эрүүл сэтгэл зүйтэй, нийгэмд нийцсэн иргэн болгож хүмүүжүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг. Швейцар Улсын хувьд 2003 онд баталсан Насанд хүрээгүй хүний Эрүүгийн хууль (Juvenile Criminal Act) нь 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж, тус хуулиар насанд хүрээгүй хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагыг илүү өргөн, уян хатан байдлаар зохицуулсан юм. Түүнчлэн 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Насанд хүрээгүйчүүдийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг батлан гэмт хэргийн үйлдэлд бус гэмт хэрэгтэнд шийтгэлд бус шинэчлэл, боловсролд анхаарлаа хандуулах зорилгыг тавьсан байна.²⁴

Азийн улсуудаас Япон, БНСУ, Энэтхэг зэрэг улсууд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд АНУ-ын жишгээр Juvenile law буюу насанд хүрээгүй хүний хэргийг хянан шийдвэрлэх тусгай хуулийг батлан хэрэгжүүлж байна. Япон улсад 20 дугаар зууны эхээс АНУ-ын өсвөр насны хүний шүүхийн жишгийг судалж, “Parents patriae” (эцэг эхийн тухай сургаал) онолыг тус улсад нэвтрүүлжээ. 1911 оноос Зөвлөл анх хуралдаж, 1922 онд Өсвөр насны хүний хууль (Juvenile Law) болон Засан хүмүүжүүлэх сургуулийн тухай хууль (Correctional School Law) тус тус батлагдсан юм. Тус хуулийн 1 дүгээр зүйлд өсвөр насны хүн нь 18 наснаас доош насны этгээд байхыг тодорхойлж, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хамгаалалтын арга хэмжээ оногдуулахаар хуульчилсан юм.²⁵

Өмнөд Солонгос Улс 1958 онд Насанд хүрээгүй хүмүүсийн хууль (Juvenile Law)-ийг насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийн нийгмийн орчныг сайжруулах, хүмүүжүүлэх тогтолцоог хангах зорилгоор баталсан. Өөрөөр хэлбэл, энэ хуулийн зорилго нь насанд хүрээгүй гэмт хэрэгтнийг шийтгэхээс илүүтэй тэднийг өөрчлөх, засан хүмүүжүүлэх явдал юм. Түүнчлэн тус улсад Juvenile Court байгуулж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн эрхийг хангах, насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх процессыг иж бүрэн хэрэгжүүлж байгаараа Азийн бусад орнуудад шилдэг туршлагыг нэвтрүүлж байна.

3. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах зорилго, хэрэглэх зарчмыг тодорхойлжээ.

Процессын загвар хуулиар насанд хүрээгүй хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлсон ба үүнд нэгдүгээрт пропорциональ байдлын зарчим юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь насанд хүрээгүй хүний сайн сайхан байдлыг чухалчилж,

²³ Реабилитацийн систем гэдэг нь өвчтөн, гэмтэл авсан хүн, эсвэл сэтгэл санааны бэрхшээлтэй хүмүүсийн биеийн болон сэтгэл санааны байдлыг сайжруулах, тэднийг хэвийн амьдралд эргэн оруулахад чиглэсэн эмнэлгийн болон нийгмийн үйлчилгээний цогц үйл ажиллагааны багц юм. Энэ нь төрөл бүрийн эмчилгээ, дасгал хөдөлгөөн, сэтгэл заслын үйлчилгээ, амьдрах орчны зохион байгуулалт зэрэг олон төрлийн арга хэмжээтэй холбоотой байдаг.

²⁴ <https://www.defenceforchildren.org/wp-content/uploads/2015/05/Switzerland-CRC-template.pdf>

²⁵ Minoru Yokoyama, Discussion on Application Age of Japanese Juvenile Law before 2015, Kokugakuin Journal of Law and Politics, Vol 59, №2, 2021

насанд хүрээгүй хүнд үзүүлэх аливаа хариу үйлдэл нь тухайн хүн болон гэмт хэргийн нөхцөл байдалтай пропорциональ байх ёстой²⁶ гэж үздэг. Энэ заалт НҮБ-ын өсвөр насны хүнд хэрэглэх шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм (Бээжингийн дүрэм)-ийн 1.4 дүгээр зүйлд мөн тусгагдсан ба аливаа улс өсвөр насны хүмүүсийн шүүн таслах ажиллагааг үндэсний хөгжлийн салшгүй хэсэг гэж ойлгоно” гэсэн төдийгүй насанд хүрээгүй хүний хэрэг хянан шийдвэр ажиллагаа (Juvenile Justice) нь гэмт хэрэгтэн (хувийн, нийгмийн, гэр бүлийн байдал) болон гэмт хэргийн нөхцөл байдал, учруулсан хохирол зэрэг нь пропорциональ байдлаар хариу үзүүлэх зорилгыг агуулах тухай заажээ. Өөрөөр хэлбэл, өсвөр насны хүний сайн сайханд байдалд дэмжлэг үзүүлэх, насанд хүрээгүй хүнд гэмт хэргийн хүнд хөнгөнөөс шалтгаалахын зэрэгцээ хувийн байдлыг харгалзан ял оногдуулах явдал юм. Дээрх зарчмын хувийн байдлыг тодорхойлох тухай заалт ЭХХШТХ-ийн 18.3 дугаар зүйлд тодорхойлогдсон байдаг боловч 18.2 дугаар зүйлд заасан баримтлах нийтлэг шаардлага хэсэгт хуульчлагдаагүй учир дутагдалтай.

Процессын загвар хуулиар тогтоосон дараагийн зарчим нь насанд хүрээгүй хүнтэй харьцахдаа хүний нэр төр, үнэ цэнийн мэдрэмж, эрх, эрх чөлөөг хүндэтгэх, түүний нас, хүсэл эрмэлзлийг харгалзан үзэж, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, нийгэмд үүрэг гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх зэрэг юм. Энэ заалт нь ЭХХШТХ-ийн 18.2 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан “... эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангана, ... нэр төрийг хүндэтгэн харьцаж, хүмүүжих, алдаагаа засах боломж олгохыг анхаарч ажиллана” гэсэн заалтуудаар хангагдсан гэж үзэж болохоор байна.

Дараагийн зарчим болох хүүхдийн талаарх бүхий ажиллагаанд түүний эрх ашгийг нэн тэргүүнд анхаарах, хэрэг хянан шийдвэрлэх бүхий л ажиллагаанд насанд хүрээгүй хүний хувийн нууцыг хамгаалах, хууль бусаар сурталчлах, шошголох үйл явцаас болж түүнд хохирол учруулахаас зайлсхийх, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангах зарчим нь ЭХХШТХ-ийн 18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “*ЭХХША-г хаалттай явуулж, шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзана*” гэж хуульчилснаар хангагджээ. Түүнчлэн насанд хүрээгүй хүнд холбогдох хэргийг цаг алдалгүй, шуурхай шийдвэрлэх зарчим нь ЭХХШТХ-ийн 18.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “*Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг шүүх хангаж ажиллана.*”²⁷ гэсэн заалтаар хангагдсан байна. Иймд Процессын загвар хуульд заасан зорилго, зарчмыг ЭХХШТХ-ийн 18 дугаар зүйлээр хангаж чадсан нь сайшаалтай гэж үзэж байна.

4. Насанд хүрээгүй хүнийг өөрчлөх хөтөлбөрүүдийг (Juvenile diversion program) хэрэгжүүлэх тухай Процессын загвар хуульд маш тодорхой дэлгэрэнгүй хуульчилжээ.

Хууль тогтоох эрх бүхий байгууллага нь хүүхдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо (Criminal justice system) -оос шилжүүлэх хөтөлбөрийг бий болгох шаардлагатай. Үүнд: насанд хүрээгүй хүнд зөвлөгөө өгөх, “амьдрах ухаан”-ы сургалтад хамруулах, насанд хүрсэн хүний хяналтад өгөхөөр прокуророос даалгах, хөдөлмөр эрхлэх болон бусад мэргэжлийн сургалтад хамруулах, эвлэрүүлэн зуучлах, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах зэрэг олон төрлийн арга хэмжээнүүд багтана. Эдгээр өөрчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ насанд хүрээгүй хүн өөрийн үйлдлийнхээ хариуцлагыг хүлээн зөвшөөрч, хохирогчтой эвлэрэхэд бэлэн байгаа эсэх, өөрийг нь шилжүүлэхийг зөвшөөрч байгаа эсэхийг шалгана. Энэхүү зөвшөөрсөн байдал нь НҮБ-ын өсвөр насны хүнд хэрэглэх шүүн таслах

²⁶ Процессын загвар хууль, 325 дугаар зүйл.

²⁷ ЭХХШТХ-ийн 18.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм (Бээжингийн дүрэм)-ийн 11.3-т заасны дагуу нэн чухал юм.

Насанд хүрээгүй хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчин, өнөөгийн байдал

ЭХХШТХ-ийн 18 дугаар бүлэгт “Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх” гэсэн тусгайлсан гарчигтайгаар өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх заалтуудыг онцгойлон зохицуулж хуульчилсан. Өөрөөр хэлбэл, өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг давхар баримтлахыг хуульчилжээ. Тус бүлэгт өсвөр насны хүнд 5.2 дугаар зүйлд зааснаар заавал өмгөөлөгч томилох тухай, шаардлагатай гэж үзвэл сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн асуудал эрхэлсэн ажилтныг байлцуулж болох талаар ерөнхий журмыг 18.1-р зүйлд заасан бол 18.2 дугаар зүйлд баримтлах шаардлагыг, 18.3 дугаар зүйлд насанд хүрээгүй хүний хувийн байдлыг тогтоох, хэргийг тусгаарлаж шийдвэрлэхийг 18.4 дүгээр зүйлд тодорхойлжээ. Түүнчлэн тус бүлэгт насанд хүрээгүй хүнийг дуудан ирүүлэх, баривчлах, мөрдөн байцаалтад хууль ёсны төлөөлөгч оролцох, цагдан хорих, хавтаст хэрэгтэй танилцуулах, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцуулах, танхимаас гаргах талаарх ажиллагааг хуульчилжээ.

ЦЕГ-аас гаргасан сүүлийн таван жилийн статистик мэдээллийг авч үзвэл, хүүхэд хохирсон, холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй байна. Тухайлбал: хүүхэд хохирсон гэмт хэрэг 2018 онд 1688, 2019 онд 1598, 2020 онд 1181, 2021 онд 1365, 2022 оны байдлаар 2014 байна. Харин хүүхэд гэмт хэрэгт холбогдсон байдлыг авч үзвэл 2018 онд 956, 2019 онд 1356, 2020 онд 990, 2021 онд 921, 2022 онд 1540 хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан.²⁸

ЦЕГ-аас гаргасан мэдээнээс үзэхэд 2021 онд 0-13 насны хүүхэд үйлдсэн гэмт хэрэг 2021 онд 216 байсан бол 2022 онд 452 болж 1 дахин нэмэгджээ. Хүйсийн хувьд авч үзвэл нийт 542 хүүхдийн эмэгтэй 20 эрэгтэй 432 байна. 14-17 насны өсвөр насны хүүхдийн хувьд 2021 онд 811 хүүхэд гэмт хэрэг үйлдсэн тоон мэдээ бүртгэгдсэн бол 2022 онд 1313 хүүхэд гэмт хэрэгт холбогджээ. 2022 онд бүртгэгдсэн нийт хэргийн 406 нь Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэрэг, 330 нь 17.1 дүгээр зүйл буюу хулгайлах гэмт хэрэг үйлдсэн бол 253 нь 11.6 дугаар зүйлд заасан хүний биед хөнгөн гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдсэн нь нийт гэмт хэргийн 75.3 хувийг эзэлж байна.

УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийнхэн өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулсан байдлыг 2021, 2022 оны III улирлын байдлаар улсын хэмжээнд хийсэн ба тус судалгаанаас үзэхэд 2021 онд 196 хэрэгт 269, 2022 оны III улирлын байдлаар 291 хэрэгт 361 гээд нийт 489 хэрэгт яллагдагчаар татагдсан 630 өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг шүүх хянан шийдвэрлэж, тогтоол, шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон байна. Нийслэлийн төвийн зургаан дүүргийн хэмжээнд 200 буюу 40.9 хувийг, орон нутагт Сэлэнгэ, Булган, Баянхонгор аймагт хамгийн их буюу 27-31 хэрэг шийдвэрлэжээ.²⁹ Шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон шүүгдэгчийн насны хувьд авч үзвэл гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн, 18 насанд хүрээгүй байсан, шүүхийн шийтгэх тогтоол гарах үед 18 насанд хүрсэн бүх хүнийг судалгаанд хамруулсан. Үүнээс үзэхэд шийтгэх тогтоол гарах үед 17 настай байсан

²⁸ Хүний эрхийн комиссод ирүүлсэн ЦЕГ-ын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 13/510 дугаар албан бичгээр ирүүлсэн статистик мэдээллээс авч ашиглав.

²⁹ УЕП-ын Сургалт судалгааны албаны судалгаа, 2022

шүүгдэгч 285 буюу 45.2 хувийг эзэлж байна. Өсвөр насны нийт шүүгдэгчийн зургаа нь буюу 0.9 хувь нь мансуурсан, 44 буюу 7 хувь нь согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн байх юм.

Шүүх өсвөр насны хүний үйлдсэн 24 төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэснээс 35.9 хувь буюу 226 хүнийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах, 26.4 хувь буюу 166 хүнийг 11.6 дугаар зүйлийн хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан, 10.3 хувь буюу 65 нь хүнийг дээрэмдэх, 4.3 хувь буюу 27 хүнийг залилах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон нь дийлэнх хувийг эзэлсэн.³⁰ Оногдуулж буй ялын тухайд шүүх 630 шүүгдэгчийн 17.5 хувь буюу 110-т нь хорих, 13.3 хувь буюу 84 хүнд зорчих эрх хязгаарлах, 9.7 хувь буюу 59-д нь нийтэд тустай ажил хийлгэх, 1.7 хувь буюу 11 хүнд торгох ял оноож, 8.1 хувь буюу 51 хүнд оногдуулсан хорих ялыг хойшлуулж, 31.3 хувь буюу 197 хүнд ял оногдуулахыг тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, 0.8 хувь буюу таван хүнд ял оногдуулахгүй тэнсэж, албадлагын арга хэмжээ авч, 11.4 хувь буюу 72-ыг нь Өршөөл үзүүлэх тухай хуульд зааснаар холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл ялыг өршөөн хэлтрүүлж, 5.4 хувь буюу 34 хүнийг ялаас чөлөөлсөн байна.

Прокурор, 488 шүүгдэгчид ял оногдуулах эрүүгийн хариуцлагын дүгнэлт гаргаснаас шүүх 253-т нь ял оногдуулсан байна. Өөрөөр хэлбэл улсын яллагч нар өсвөр насны хүнийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял, хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял сонгон эрүүгийн хариуцлага оноох дүгнэлт гаргасан. Харин шүүх ял оноохгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ түлхүү хэрэглэжээ. Мөн өсвөр насны 122 хүнд нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулах эрүүгийн хариуцлагын дүгнэлт гаргаснаас шүүх 31.1 хувь буюу 84 хүнд уг ялыг шийтгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дүн мэдээнээс үзэхэд 2021 онд 84, 2022 онд 108, 2023 онд 161, 2024 онд 243 насанд хүрээгүй хорих ялаар шийтгэгдэж сургалт хүмүүжлийн байгууллагад хоригдож байна.³¹

Дүгнэлт

Насанд хүрээгүй хүн буюу хүүхдийн эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ханган хамгаалах нь олон улсын зүгээс улс орнуудад хүлээлгэсэн онцгой үүргийн нэг юм. Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод нэгдэн орж, НҮБ-ын Хүүхдийн Шүүхийн Хэрэг эрхлэх доод жишиг дүрэм (Бээжингийн дүрэм), Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүнийг хамгаалах НҮБ-ын Удирдамж, Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын Удирдамж (Эр-Риядын удирдамж), Дэлхийн Эрүүгийн процессын загвар хуульд хууль тогтоомжоо нийцүүлэн хэрэгжилтийг анхааран ажиллах цаг хэдийн болжээ.

Өсвөр насны хүн, хүүхэд, насанд хүрээгүй хүн, насанд хүрээгүй этгээд гэх мэт нэг мөр бус нэр томьёог хэрэглэхээс татгалзан “насанд хүрээгүй хүн” гэсэн нэр томьёог хэрэглэх нь олон улсын баримт бичгүүдээр тодорхойлсонтой нийцэхүйц гэж дүгнэж байна. Мөн насанд хүрээгүй хүн гэсэн ойлголтын насны хязгаарыг 18 насанд хүрээгүй хүнийг ойлгохоор хуульчилж байгаатай санал нийлж байгаа бөгөөд насны доод хязгаарыг 14, 13, 12 гэх зэргээр тодорхойлох шаардлагыг судлах нь зүйтэй юм. Түүнчлэн Монгол Улсад 2017 оноос шинэчилсэн Эрүүгийн хууль, ЭХХШТХ-д өсвөр насны хүн гэх нэр томьёог хэрэглэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар тусгай бүлэглэн хуульчилсан төдийгүй “Шүүхээс арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно”

³⁰ Мөн тэнд.

³¹ ШШГЕГ-ын дүн мэдээнээс иш татав. 2025 оны 2 дугаар сар.

гэж хуульчилсан нь Бээжингийн дүрэмд заасан гишүүн улс орнууд нь энэхүү жишиг дүрэмд заасан жишиг хэм хэмжээг өсвөр насны хүнд хэрэглэхээс гадна тухайн улсын хуулиар насанд хүрсэн гэж тооцогдсон залуу хүнд мөн адил хэрэглэх боломжийг дотоодын хууль тогтоомжид тусгах үүрэг болгосныг хэрэгжүүлсэн заалт болжээ.

Насанд хүрээгүй хүний хэргийг шийдвэрлэхэд оролцох тусгай зөвлөл, хүүхдийн тусгайлсан шүүх байх шаардлагатай гэсэн Процессын загвар хуулийн стандартыг хэрэгжүүлэх шаардлага манай улсын ЭХХША-нд нэн тулгамдсан асуудал болжээ. Дэлхийн хөгжингүй болон бусад эрх зүйн ижил түвшний хөгжил бүхий улс орнуудад Juvenile court буюу Насанд хүрээгүй хүний тусгай шүүх ажиллаж, насанд хүрээгүй хүний хэргийг хянан шийдвэрлэх процессын хуулийг батлан хэрэгжүүлж буй энэ цаг үед Монгол Улс олон улсын энэ жишигтэй хөл нийлүүлэн алхах алхам хийх нь болжээ. Тусгайлсан шүүхийг ажиллуулснаар насанд хүрээгүй хүн болох хүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрхээ бүрэн хангуулах, хорихоос өөр бусад “өөрчлөх хөтөлбөр”-т хамрагдах, туршлагатай, мэргэшсэн шүүгчдээр хэргээ шийдвэрлүүлэх, олон улсын зарчимд нийцсэн эрх зүйн зохицуулалтуудаар хангагдах боломжтой болох юм. Түүнчлэн бусад орнуудын шилдэг туршлагыг нэвтрүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг хүмүүжүүлэх, сэтгэл зүйн болон нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх тусгай Төвийг ажиллуулж, хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс зайлсхийх, сөрөг үр дагаваргүйгээр амьдралд оруулах зорилготой олон төрлийн шийдлүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн тоон мэдээ тасралтгүй өсөж, тэр тусмаа бага насны хүүхэд (14 наснаас доош) гэмт хэрэг үйлдэх явдал нэмэгдэж байгаа энэ нөхцөлд Монгол Улс насанд хүрээгүй хүний гэмт явдал, түүнийг бууруулах, түүнтэй тэмцэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл зайлшгүй тулгамдаж байгааг судлаачийн зүгээс цохон тэмдэглэж байна. Түүнчлэн насанд хүрээгүй хүнд оногдуулж буй ялын байдалд дүгнэлт хийхэд 31.3 хувьд тэнсэх, 17.5 хувьд хорих, 13.3 хувьд зорчих эрхийг хязгаарлаж буй нь нийт оногдуулж буй ялын 62 хувийг эзэлж байна.

Монгол Улсад Diversion program буюу хэрэгтнийг өөрчлөх хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсруулах нэн шаардлагатайг дээрх тоо баримт харуулж байна. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд болон дэлхийн улсуудын туршлагад тулгуурлан реабилитацийн системийг чухалчилж, хүүхдийг эрүүл сэтгэл зүйтэй, хүнлэг, ёс зүйтэй, нийгэмд нийцсэн иргэн болгож хүмүүжүүлэхэд гол анхаарлаа хандуулах цаг тулгарчээ. Манай улс “Насанд хүрээгүй хүний Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийг тусгайлан баталж, гэмт хэргийн үйлдэлд бус гэмт хэрэгтэнд, ял шийтгэлд бус шинэчлэл, боловсрол хүмүүжилд анхаарлаа хандуулах нь нэн шаардлагатай гэж дүгнэж байна.

Санал, зөвлөмж

1. Juvenile court буюу Насанд хүрээгүй хүний шүүхийг Монгол Улсад байгуулах;
2. Эрүүгийн хууль, ЭХХШтХ-д “насанд хүрээгүй хүн” гэсэн нэр томъёог нэвтрүүлж, нэг мөр хэрэглэж хэвших;
3. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны доод хязгаарыг хүн төрөлхтний хөгжлийн онцлогт нийцүүлэн өөрчлөх хэрэгцээ шаардлага байгаа эсэхэд ул суурьтай судалгааг хийж, үр дүнг хууль тогтоогчид хүргүүлэх;
4. Монгол Улсад “Насанд хүрээгүй хүний эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийг тусгайлан батлах;
5. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд болон дэлхийн улсуудын туршлагад тулгуурлан реабилитацийн системийг чухалчилсан “Diversion program” буюу гэмт хэрэгтнийг өөрчлөх хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсруулах;
6. Насанд хүрээгүй хүний шүүхийг тусгайлан байгуулах хүртэл хугацаанд ЭХХШтХ-д нэмэлт өөрчлөлт оруулан Насанд хүрээгүй хүний хэргийг хянан шийдвэрлэх Тусгай зөвлөлийг байгуулж, хүүхдийн эрхийг хангах олон улсын наад захын жишиг стандартыг хангах.

Ашигласан материал

1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023 он.
2. Дэлхийн Эрүүгийн процессын загвар хууль, 2002 он
3. Хүүхдийн эрхийн конвенц, 2017
4. Эрүүгийн хууль, 2015
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015
6. Minoru Yokoyama, Discussion on Application Age of Japanese Juvenile Law before 2015, Kokugakuin Journal of Law and Politics, Vol 59, №2, 2021
7. United Nations Standard Minimum Rules for the Administration of Juvenile Justice ("The Beijing Rules"), Article 3
8. ЦЕГ-ын дүн мэдээ, 2025
9. ШШГЕГ-ын дүн мэдээ, 2025
10. УЕПГ-ын дүн мэдээ, 2025
11. ШЕЗ-ийн дүн мэдээ, 2025